ХХААХҮЯ, Сангийн яам, Капитал банкны хооронд 2011 оны 11 дүгээр сарын 07-д байгуулсан ННБ 2011/8/87 тоот “Засгийн газраас гаргасан бондын эх үүсвэрээр бүрдэх хөрөнгийн дамжуулан зээлдүүлэлтийг хамтран хэрэгжүүлэх гэрээ”, Аж үйлдвэрийн яам, Капитал банк хоорондын 2016 оны 01 дүгээр сарын 26-ны өдөр байгуулсан 2016/ҮГ-05 тоот “Хамтран ажиллах” гэрээний дагуу Капитал банкнаас эргэн төлөөгүй 42,901.3 сая төгрөгийн авлага бүртгэлтэй байна. Капитал банк ХХК дахь банкны эрх хүлээн авагчийн 2019 оны 9 сарын 27-ны өдрийн 1705 дугаар мэдэгдлээр уг төлбөрийн үлдэгдэлд бүртгэгдэж баталгаажуулснаа мэдэгдсэн бөгөөд өнөөг хүртэл төлөлт хийгдээгүй байна.

Татаас санхүүжилт, байгууллага, хувь хүнээс авах нийт 92.2 сая төгрөгийн авлагад нэмэлт санхүүжилтийн татаас санхүүжилтийн 40.6 сая төгрөгийн, тоног төхөөрөмж, саалтуурын зээлээр борлуулсны 43.4 сая төгрөгийн, бусад 8.2 сая төгрөгийн авлага байна.

Бусад авлагаас Булган, Төгсбат нарын нэр дээр үүссэн 1.4 сая төгрөгийн авлага хэзээ үүссэн нь тодорхойгүй, найдваргүй авлага үүсэх эрсдэл үүссэн байгаад анхаарч, барагдуулах арга хэмжээ авах шаардлагатай байна.

Нийт урт хугацаат өр төлбөрийн үлдэгдэлд Сангийн яаманд төвлөрүүлэх 43,646.7 сая төгрөгийн Засгийн газрын бондын, ХХААХҮС, Өмнөговь аймгийн Засаг дарга нарын хооронд байгуулсан 190717/01/247 тоот гурвалсан гэрээний дагуу буцаан төвлөрүүлэх 1,445.2 сая төгрөгийн дамжуулан зээлийн өглөг тус тус бүртгэлтэй байна.

Богино хугацаат өр төлбөрийн 66.8 сая төгрөгийн үлдэгдэлд харилцагч тодорхойгүй болон зээлийн эргэн төлөлтийг урьдчилан шилжүүлсэн 59.4 сая төгрөгийн урьдчилж орсон орлого, 5.7 сая төгрөгийн нийгмийн даатгалын шимтгэлийн, 1.7 сая төгрөгийн бусад өглөг тус тус бүртгэлтэй байна.

Цэвэр хөрөнгө өмчийн дүн 16,371.3 сая төгрөгөөр буурсан нь Жижиг дунд үйлдвэрийн газар, Мал хамгаалах сангийн хөрөнгө, өглөг, авлагыг шилжүүлж, өмнөх үеийн үр дүнг бууруулсантай холбоотой байна.

Жижиг, дунд үйлдвэрийг хөгжүүлэх сангийн санхүүгийн үр дүнгийн тайлангаар үндсэн үйл ажиллагааны орлого өмнөх оноос 4,505.6 сая төгрөгөөр буюу 35.6 хувиар буурсан байна. Энэ нь короновируст цар тахалт гарч, жижиг, үйлдвэр, үйлчилгээ эрхлэгчдийн бизнесийн тогтвортой байдлыг хангах, ажлын байрыг хадгалах зорилгоор ХХААХҮС-ын 2020 оны А/84, А/373 дугаар тушаалын дагуу зээлийн хүү, алданги тооцооллыг 6 сарын хугацаагаар зогсоосонтой холбоотой.

Нийт зардал өмнөх оноос 493.0 сая төгрөгөөр буюу 37.3 хувиар өссөн байна. Энэ нь Засгийн газрын 2013 оны 250 дугаар тогтоолын хүрээнд хэрэгжсэн “Сурагчийн дүрэмт хувцасны үндэсний үйлдвэрлэлийг дэмжих” зээлийн эргэн төлөлтөд 409.0 сая төгрөгийг дамжуулан барагдуулсан, мөн тус сангийн бүтэц зохион байгуулалтын өөрчлөлттэй холбоотойгоор ажлаас халагдсаны тэтгэмж, ажлаас үндэслэлгүй халагдсаны нөхөн олговор зэрэгт олгох нэг удаагийн тэтгэмжийн зардал нэмэгдсэн нь голлон нөлөөлсөн байна.

3.6. Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт санхүүжилт

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь энэ хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

Төсвийн төлөвлөлт

Жижиг, дунд үйлдвэрийг хөгжүүлэх сан нь 2020 оны төсвийн төслийг аудитад хамруулаагүй бөгөөд тайлант онд төсвийн захирагчийн хэрэгжүүлэх “Жижиг, дунд үйлдвэрийг дэмжих, хөгжүүлэх, ажлын байр бий болгох” хөтөлбөрийн хүрээнд 7 арга хэмжээг санхүүжүүлэхээр 50,635.8 сая төгрөгийн төсөв батлагдсанаас 400.0 сая төгрөгийг улсын төсвийн санхүүжилтээр, 51,235.8 сая төгрөгийг үндсэн үйл ажиллагааны орлогоос бүрдүүлэхээр төсөв батлагджээ.

Төсвийн гүйцэтгэл

Гүйцэтгэлээр үндсэн үйл ажиллагааны хүрээний орлогоос 24,393.2 сая төгрөгийн эх үүсвэр бүрдүүлж, үйл ажиллагааны урсгал зардалд 993.4 сая төгрөгийг зарцуулж, эргэж төлөгдөх зээлд 22,816.4 сая төгрөгийг олгож, 583.3 сая төгрөгийг бондын төлбөрт тооцон татан төвлөрүүлсэн байна.

Үндсэн үйл ажиллагааны орлого 27,425.9 сая төгрөгөөр тасарсан нь Коронавируст цар тахлын улмаас Засгийн газрын болон төсвийн ерөнхийлөн захирагчийн шийдвэрээр зээлийн үндсэн төлбөр, алдангийн төлбөрийг 6 сарын хугацаатай зогсоосон нь голлон нөлөөлжээ.

Сангийн төсвийн нийт зардал 27,825.9 сая төгрөг буюу 46.1 хувийн гүйцэтгэл байгаа нь зээлийн эргэн төлөлт зогссоноос 27,425.9 сая төгрөгийн зээл олгогдоогүй, Жижиг, дунд үйлдвэрийн газрын 4 дүгээр улирлын төсвийг салган шилжүүлсэнтэй холбоотойгоор урсгал зардал 233.4 сая төгрөгөөр дутуу гүйцэтгэлтэй тайлагнагдсан байна.

Нэмэлт санхүүжилт

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Сангийн сайдын 2019 оны 251 тоот тушаалаар 304.0 сая төгрөгийн давсан орлогыг зарцуулах эрх авч, эд хогшил урсгал засварын зардалд 194.6 сая төгрөгийг, нэг удаагийн тэтгэмжийн зардалд 69.2 сая төгрөгийг тус тус зарцуулан, үлдэгдэл 40.2 сая төгрөгийг улсын төсөвт төвлөрүүлжээ.

3.7. Шилэн дансны мэдээлэл

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор батлагдсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Тайлант хугацаанд Шилэн дансны нэгдсэн цахим системд 20 төрлийн 149 мэдээлэл оруулахаас 106 мэдээллийг хугацаанд нь бүрэн, 9 мэдээллийг дутуу, 29 мэдээллийг хугацаа хоцроон байршуулж 5 мэдээллийг огт байршуулаагүй байна.

Дараах мэдээллүүдийг холбогдох хууль, журмын дагуу бүрэн мэдээлж, байршуулаагүй байна. Үүнд:

- Дараа жилийн төсвийн төсөл, санхүүгийн тайланд хийсэн аудитын дүгнэлт, Худалдан авах ажиллагааны тайлан, байгууллагын батлагдсан төсөв, аудитын тайлан, дүгнэлт, зөвлөмжийн мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний тайлан зэрэг 5 мэдээллийг мэдээлээгүй,

- Таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий 9 байгууллагаас худалдан авсан 298.1 сая төгрөгийн бараа, ажил үйлчилгээний нэр, санхүүжилтийн хэмжээ, нийлүүлэгчийн нэр, хаяг зэргийг мэдээлээгүй,
- Батлагдсан төсөв, гүйцэтгэл, хэтрэлт хэмнэлтийн шалтгаан тайлбарыг сүүлийн 3 сард мэдээлээгүй, зарим сард дутуу мэдээлсэн байна.

3.8. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийг мөрдөн ажиллаж байх зөвлөмжийг хэрэгжүүлээгүй байна.

3.9. Аудитын илрүүлэлт

Аудитаар нийт 169,842.9 сая төгрөгийн алдаа зөрчил илэрснээс, 11,225.0 сая төгрөгийн 7 алдааг залруулж, 158,617.9 сая төгрөгийн зөрчлийг арилгах 4 албан шаардлага хүргүүлж, алдаа зөрчлийг давтан гаргахгүй байх 1 зөвлөмж өглөө.

Залруулсан алдаа

Аудитаар нягтлан бодох бүртгэлийн бичилт, тооцоолол болон тайлагналын 11,225.0 сая төгрөгийн дараах алдааг санхүүгийн тайланд тусгаж, залруулга хийлгэн баталгаажуулав. Үүнд:

1. Санхүүгийн тайлангийн бүрэлдэхүүн буюу төсвийн гүйцэтгэлийн тайланг хуулийн хугацаанд гаргаж ирүүлээгүй, аудитын хугацаанд нөхөн гаргасан;
2. Санхүүгийн тайлангийн тэнцэл хангаагүй, нийт хөрөнгө, өр төлбөр, эзний өмчийн дүнг 0.5 сая төгрөгөөр зөрүүтэй тайлагнасан;
3. Үр дүнгийн тайланд үндсэн үйл ажиллагааны орлогыг 1,076.8 сая төгрөгөөр бууруулан, сөрөг утгаар тайлагнасан;
4. Жижиг, дунд үйлдвэрийг хөгжүүлэх сангийн зээлийн эргэн төлөлтийн орлогоос Засгийн Газрын бондын төлбөр, Монгол улсын хөгжлийн банкнаас авсан зээлийн төлбөр зэрэг нийт 8,725.2 сая төгрөгийн гүйлгээг мөнгөн гүйлгээний тайланд орлого бууруулан тайлагнасан;
5. Жижиг, дунд үйлдвэрийн газарт балансаас балансд шилжүүлсэн 1,366.9 сая төгрөгийн бараа материалыг бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний төлбөр хураамжийн зардлаар тайлагнасан;
6. Хөрөнгө бэлтгэхээр урьдчилан шилжүүлсэн 15.0 сая төгрөгийн төлбөрийг балансаас балансд шилжүүлэхдээ данс буруу бүртгэсэн;
7. Нэмэлт санхүүжилтийн дансны 40.6 сая төгрөгийн үлдэгдлийг улсын төсөвт төвлөрүүлж, авлагаар тооцоо нийлсэн ч, тайлант үеийн зардлаар бүртгэснийг залруулга хийлгэлээ.

Зөвлөмж өгөхөөс бусад байдлаар шийдвэрлэсэн алдаа, зөрчил

Аудитаар 158,617.9 сая төгрөгийн залруулагдаагүй алдаа, зөрчилд 4 албан шаардлага хүргүүлээ. Үүнд:

1. Жилийн эцсийн санхүүгийн тайлан гаргахын өмнө нийт харилцагчидтай тооцоо нийлж баталгаажуулах ажил хангалтгүй, нийт авлагын 57.1 хувь буюу 156,314.6 сая төгрөгийн, нийт өглөгийн 4.6 хувь буюу 2,097.0 сая төгрөгийн үлдэгдлийг баталгаажуулаагүй, зарим аж ахуйн нэгжтэй хийсэн тооцоо 195.4 сая төгрөгөөр зөрүүтэй байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д "Аж ахуйн нэгж, байгууллага нягтлан бодох бүртгэлийн дараах зарчмыг баримтална", 5.1.4-т "үнэн зөв байх", 13 дугаар зүйлийн 13.1-д "Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно", 20 дугаар зүйлийн 20.2.6-д "эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн

нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах" гэж заасантай тус тус нийцээгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Дээрх зөрчлийг давтан гаргахгүй байх, бараа, ажил үйлчилгээг худалдан авахдаа холбогдох хуулийг мөрдөж ажиллах албан шаардлага хүргүүлээ.

2. Төрийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах ажиллагаанд мөрдөх босго үнээс давсан 5 удаагийн 125.7 сая төгрөгийн худалдан авалтад холбогдох хууль, журмын дагуу гүйцэтгэгчийг сонгон шалгаруулаагүй, шууд гэрээ байгуулсан байна.

Энэ нь ТБОНӨХБАҮХА тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-т "Худалдан авах ажиллагаанд ил тод, өрсөлдөх тэгш боломжтой, үр ашигтай, хэмнэлттэй, хариуцлагатай байх зарчмыг баримтална", 8.4-т "Төндөр шалгаруулалтын журмыг сонгоходоо тухайн бараа, ажил, үйлчилгээний нийт төсөвт өртгийг үндэслэл болгоно" гэж заасныг болон Засгийн газрын 2013 оны 68 дугаар тогтоолоор баталсан "Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах ажиллагаанд мөрдөх журмыг сонгоход баримтлах босго үнэ"-д заасантай тус тус нийцээгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Дээрх зөрчлийг давтан гаргахгүй байх, бараа, ажил үйлчилгээг худалдан авахдаа холбогдох хуулийг мөрдөж ажиллах албан шаардлага хүргүүлээ.

3. Ажлаас үндэслэлгүй халагдсан нэр бүхий 4 ажилтанд шүүхийн шийдвэрээр ажилгүй байсан хугацааны нөхөн олговорт нийт 80.7 сая төгрөгийг цалингийн болон нэг удаагийн тэтгэмж урамшууллын зардлаас олгосон байна.

Энэ нь Захиргааны ерөнхий хуулийн 103 дугаар зүйлийн 103.1-т "Иргэн, хуулийн этгээдийн хохирлыг барагдуулсны улмаас өөрт учирсан хохирлыг захиргааны байгууллага Иргэний хуулийн 498.5-д заасны дагуу гэм буруутай албан тушаалтнаар буцааж төлүүлнэ" гэж заасантай нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Шүүхийн шийдвэрээр ажилгүй байсан хугацааны нөхөн олговорт олгосон зардлыг буруутай шийдвэр гаргасан этгээдээр нөхөн төлүүлэх арга хэмжээг авах албан шаардлага хүргүүлээ.

4. Шилэн дансны нэгдсэн цахим хуудсанд 5 төрлийн мэдээлэл байршуулаагүй, 9 мэдээлэл дутуу, 29 мэдээлэл хугацаа хоцроон байршуулсан байна.

Энэ нь Шилэн дансны тухай хуулийн 4 дүгээр зүйлийн "Шилэн дансны зарчим 4.1-д "Энэ хуулийг хэрэгжүүлэхэд дараах зарчмыг баримтална", 4.1.1-д "мэдээлэл үнэн зөв, бодитой, иж бүрэн байх", 4.1.3-т "тогтоосон хугацаанд, тогтмол, шуурхай мэдээлдэг байх", 6 дугаар зүйлийн 6.1.1, 6.1.3, 6.1.5, 6.4.6 заалтуудтай тус тус нийцээгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Дээрх зөрчлийг арилгах, давтан гаргахгүй байх албан шаардлага хүргүүлээ.

Аудитын зөвлөмж

Аудитаар санхүүгийн тайланг иж бүрэн гаргаж байх зөвлөмж өгснийг менежментийн захидалд тусгав.

3.10. Балансын дараах үйл явдал болон дараагийн аудитаар авч үзэх анхаарал татахуйц бусад чухал асуудлууд

Аудитын явцад анхаарал татахуйц, дараагийн аудитаар авч үзэх дараах асуудлууд байна. Үүнд:

- Жижиг, дунд үйлдвэрийг дэмжих сангийн зээлийн эргэн төлөлтийн орлогоос тус сангийн төсөвт тусгагдаж батлагдаагүй 6,201.7 сая төгрөгийн бондын төлбөр, Монгол улсын хөгжлийн банкинд шүүхийн шийдвэрийн дагуу 3,520.8 сая төгрөгийн

зээлийн төлбөр, 415.2 сая төгрөгийн хүүгийн төлбөрт тус тус төлж, энэ хэмжээгээр төсвийн гүйцэтгэлийн тайланд орлого бууруулан тохируулж тайлагнасан байна.

Дээрх арга хэмжээний төлөвлөлт, гүйцэтгэл, тайлагналыг Засгийн газрын нэгтгэсэн санхүүгийн тайлангийн аудитаар нарийвчлан авч үзэх нь зүйтэй байна.

- Засгийн газрын 2020 оны 113 дугаар тогтоолоор баталсан “Жижиг, дунд үйлдвэрийг хөгжүүлэх сангаас хөнгөлөлттэй зээл олгох, сонгон шалгаруулах, дамжуулан зээлдүүлэх, эргэн төлүүлэх, хяналт тавих журам” шинэчлэн батлагдсан бөгөөд дараагийн аудитаар тус журмын санхүүгийн үйл ажиллагаа, дотоод хяналттай холбоотой зохицуулалтуудын хэрэгжилтэд нарийвчилсан горим сорил хэрэгжүүлнэ.
- Жижиг, дунд үйлдвэрийг хөгжүүлэх сангийн ажлын албаны орон тоонд батлагдаагүй 6 үйлчилгээний ажилтан авч ажиллуулан, цалингийн зардлаас 27.4 сая төгрөгийг зарцуулсан байна. Энэ нь Төсвийн тухай хуул, Засгийн Газраас баталсан орон тооны хязгаартай нийцэхгүй байгаад анхаарах шаардлагатай байна.
- Тус сангийн зээлийн тооцооллыг “Fiscus” программаар, нягтлан бодох бүртгэлийг “Dynamic” программаар тус тус хөтөлж, дахин нэгтгэн санхүүгийн тайлан гаргаж байгаа нь цаг хугацаа, хүний нөөцийн дутагдал үүсгэж, алдаа, зөрчил гарах эрсдэлтэй байгаад анхаарч, программ хангамжийн ашиглалтыг сайжруулахад шаардлагатай байна.
- Мөн сангийн жилийн эцсийн санхүүгийн тайланг Засгийн газрын санхүү, төсвийн гүйцэтгэлийн Э-тайлангийн нэгдсэн системд тайлагнахдаа орлого, авлага, өглөгийн зарим дансыг нэгтгэн тайлагнаж, жилийн эцсийн тайланг 2 өөр байдлаар илэрхийлж байна. Цаашид сангийн нягтлан бодох бүртгэл хөтлөлтөд Сангийн сайдын баталсан дансны ангиллыг баримтлан ажиллах шаардлагатай байна.

4. Менежментийн захидал

Менежментийн захидалд цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлоор нь эрэмбэлэн үзүүлэв. Үүнд:

1. Санхүүгийн тайлагналтай холбоотой асуудал

2.1. Илрүүлэлт:

Санхүүгийн тайлангийн бүрэлдэхүүн буюу тодруулга, тэмдэглэл бэлтгэж гаргаагүй нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1-д "Санхүүгийн тайлагналын олон улсын стандартын дагуу нягтлан бодох бүртгэл хөтөлж, санхүүгийн тайлангаа гаргах үүрэг бүхий аж ахуйн нэгж, байгууллагын санхүүгийн тайлан нь дараах бүрэлдэхүүнтэй байна: 8.1.5.санхүүгийн тайлангийн тодруулга", Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаалаар баталсан заавар, журамтай нийцээгүй байна.

2.2. Эрсдэл:

Санхүүгийн тайлан иж бүрэн илэрхийлэгдэхгүй байх, санхүүгийн тайлан дахь мэдээлэл бүрхэг тодорхой бус болох, холбогдох стандарт, хууль, журам зөрчигдөх;

2.3. Өгсөн зөвлөмж:

Санхүүгийн тайлангийн тодруулга, тэмдэглэлийг гаргаж санхүүгийн тайланг иж бүрэн, үнэн зөв тайлагнаж байх;

2.4. Байгууллагаас өгсөн хариу тайлбар:

Аудитаар өгч буй зөвлөмжийг хэрэгжүүлэн ажиллана.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2021 оны 9 дүгээр сарын 15-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн жагсаалт

Огноо:	Аудитын нэр:	Жижиг, дунд үйлдвэрийг хөгжүүлэх сангийн 2020 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит	Аудитын код:
2020			САГ-2020/4/СТА-ЗГТС
Шалгагдсан байгууллагын нэр:	Жижиг, дунд үйлдвэрийг хөгжүүлэх сан		Сая төгрөг

№	Алдаа, зөрчлийн товч утга	Мөнгөн дүн	Аудитын байгууллагаас гаргасан шийдэл	Алдаа, зөрчилтэй асуудал гаргасан албан тушаалтны	
			Нэр	Албан тушаал	Овог нэр
	1	2	3	4	5
1	Жижиг, дунд үйлдвэрийг хөгжүүлэх сан нь жилийн санхүүгийн тайлан гаргахын өмнө нийт харилцагчидтай тооцоо нийлж баталгаажуулах ажил хангалтгүй, нийт авлагын 57.1 хувь буюу 156,314.6 сая төгрөгийн, нийт өглөгийн 4.6 хувь буюу 2,097.0 сая төгрөгийн өглөгийн үлдэгдлийг баталгаажуулаагүй, зарим аж ахуйн нэгжтэй хийсэн тооцоо 195.4 сая төгрөгөөр зөрүүтэй байна.	158,411.5	Албан шаардлага өгөх	Дарга, Ерөнхий нягтлан бодогч	Я.Эрдэнэсайхан, Б.Сэргэлэн
2	Босго үнээс давсан 5 төрлийн 125.7 сая төгрөгийн худалдан авалтад холбогдох хууль, журмыг мөрдөөгүй.	125.7	Албан шаардлага өгөх	Дарга, Ерөнхий нягтлан бодогч	Я.Эрдэнэсайхан, Б.Сэргэлэн
3	Шүүхийн шийдвэрийн дагуу 4 ажилтанд 80.7 сая төгрөгийн нөхөн олговор олгосныг буруутай албан тушаалтнаар нөхөн төлүүлээгүй байна. Үүнээс 14.6 сая төгрөгийг цалингийн сангаас, 7.2 сая төгрөгийг нийгмийн даатгалын шимтгэлийн зардлаас, 58.9 сая төгрөгийг нэмэлт санхүүжилтээс зөвшөөрөлгүй зарцуулсан байна.	80.7	Албан шаардлага өгөх	Дарга, Ерөнхий нягтлан бодогч	Я.Эрдэнэсайхан, Б.Сэргэлэн
4	Санхүүгийн тайлангийн бүрэлдэхүүн буюу тодруулга, тэмдэглэл бэлтгэж гаргаагүй байна.		Зөвлөмж хүргүүлэх	Дарга, Ерөнхий нягтлан бодогч	Я.Эрдэнэсайхан, Б.Сэргэлэн
5	Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийг хангаж ажиллаагүй, 5 төрлийн мэдээлэл огт байршуулаагүй, 11, 12 дугаар саруудад шилэн дансны цахим хуудас дутуу хөтөлснөөс 9 мэдээлэл дутуу оруулж, 29 мэдээлэл хугацаа хоцроон байршуулсан байна.		Албан шаардлага өгөх	Дарга, Ерөнхий нягтлан бодогч	Я.Эрдэнэсайхан, Б.Сэргэлэн
ДҮН		158,617.9			



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

᠒᠐᠒1 оны ᠐3 дугаар сарын ᠒᠘

№ 45Т/А.016᠐᠐᠖8

Улаанбаатар хот

САТ - ᠒᠐᠒1/4/᠒᠑А-3ГТС

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд хийсэн Жижиг, дунд үйлдвэрийг хөгжүүлэх сангийн 2020 оны санхүүгийн тайлангийн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

- Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст нийт 149 мэдээлэл байршуулахаас 5 төрлийн мэдээлэл огт байршуулаагүй, 9 удаагийн мэдээлэл дутуу, 29 удаагийн мэдээлэл хугацаа хоцроон байршуулсан байна.

Энэ нь Шилэн дансны тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.1-д “мэдээлэл үнэн зөв, бодитой, иж бүрэн байх”, 4.1.3-т “тогтоосон хугацаанд, тогтмол, шуурхай мэдээлдэг байх”, 6 дугаар зүйлийн 6.1.1-т “тухайн жилийн төсөв, худалдан авах ажиллагааны төлөвлөгөө, орон нутгийн хөгжлийн сангийн төлөвлөлтийг жил бүрийн 01 дүгээр сарын 10-ны өдрийн дотор”, 6.1.3-т “дараа жилийн төсвийн төслийг жил бүрийн 09 дүгээр сарын 15-ны өдрийн дотор”, 6.1.5-д “төсвийн ерөнхийлөн захирагчийн төсвийн багцад хийсэн аудитын дүгнэлтийг бүрэн эхээр нь тухайн жилийн 04 дүгээр сарын 25-ны өдрийн дотор, аудитын тайлан, дүгнэлтэд тусгагдсан асуудлаар авч хэрэгжүүлсэн арга хэмжээг тухайн жилийн 07 дугаар сарын 01-ний өдрийн дотор” гэж заасныг тус тус хэрэгжүүлж ажиллаагүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-т “Шалгаагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө”, Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан “Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох” журмын 4.2.1-т заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Шилэн дансны тухай хууль тогтоомжийг хэрэгжүүлж, мэдээллийг хуулийн хугацаанд ил тод, бүрэн байршуулах арга хэмжээг авч, дээрх зөрчлийг давтан гаргахгүй байхад анхаарч албан шаардлагын биелэлтийг 2021 оны 9 дүгээр сарын 15-ны өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх;
2. Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Жижиг, дунд үйлдвэрийн газрын дарга Я.Эрдэнэсайхан, ерөнхий нягтлан бодогч Б.Сэргэлэн нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

АУДИТЫН ДӨРӨВДҮГЭЭР ГАЗРЫН ЗАХИРАЛ,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

Я.САМБУУНЯМ

АХЛАХ АУДИТОР

Б.ЭРДЭНЭЗУЛ

Монгол Улс, Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, 1-р хороо, Бага тойруу-3, Засгийн газрын 4 дүгээр байр,
Утас 51-264230

10.10.20\Bichig_Khereg\Alban_Shaardlaga\2021\0325audit\m 2-R_Gazar62.Docx

001080873



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

᠒᠐᠒1 оны ᠒3 дугаар сарын ᠒5

№ 458/᠒᠐1᠖᠐᠐᠐᠑3

Улаанбаатар хот

САГ - ᠒᠐᠒1 / 4 / СА - З ГТЦ,
Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд хийсэн Жижиг, дунд үйлдвэрийг хөгжүүлэх сангийн 2020 оны санхүүгийн тайлангийн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

- Ажлаас үндэслэлгүй халагдсан нэр бүхий 4 ажилтанд шүүхийн шийдвэрээр ажилгүй байсан хугацааны нөхөн олговорт нийт 80,692,132.83 мөнгийг байгууллагаас олгосон байна.

Энэ нь Захиргааны ерөнхий хуулийн 103 дугаар зүйлийн 103.1-т "Иргэн, хуулийн этгээдийн хохирлыг барагдуулсны улмаас өөрт учирсан хохирлыг захиргааны байгууллага Иргэний хуулийн 498.5-д заасны дагуу гэм буруутай албан тушаалтнаар буцааж төлүүлнэ" гэж заасантай нийцэхгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-т "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох" журмын 4.2.1-т заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Шүүхийн шийдвэрээр ажилгүй байсан хугацааны нөхөн олговорт олгосон 80,692,132.83 /наян сая зургаан зуун ерэн хоёр мянга нэг зуун гучин хоёр төгрөг наян гурван/ мөнгийг буруутай шийдвэр гаргасан этгээдээр нөхөн төлүүлэх арга хэмжээг авч, албан шаардлагын биелэлтийг 2021 оны 9 дүгээр сарын 15-ны өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх;
2. Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Жижиг, дунд үйлдвэрийн газрын дарга Я.Эрдэнэсайхан, ерөнхий нягтлан бодогч Б.Сэргэлэн нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

АУДИТЫН ДӨРӨВДҮГЭЭР ГАЗРЫН ЗАХИРАЛ
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

Я.САМБУУНЯМ

АХЛАХ АУДИТОР

Б.ЭРДЭНЭЗУЛ



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

᠒᠐᠒᠒ оны ᠐᠘ дугаар сарын ᠒᠘

№ 459/᠒᠐16᠐᠐68

Улаанбаатар хот

САГ-᠒᠒᠒1/4/СА-3ГТ,
Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд хийсэн Жижиг, дунд үйлдвэрийг хөгжүүлэх сангийн 2020 оны санхүүгийн тайлангийн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

- Төрийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах ажиллагаанд мөрдөх босго үнээс давсан 5 удаагийн 125.7 сая төгрөгийн худалдан авалтад холбогдох хууль, журмын дагуу гүйцэтгэгчийг сонгон шалгаруулаагүй, шууд гэрээ байгуулсан байна.

Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-т "Худалдан авах ажиллагаанд ил тод, өрсөлдөх тэгш боломжтой, үр ашигтай, хэмнэлттэй, хариуцлагатай байх зарчмыг баримтална", 8 дугаар зүйлийн 8.4-т "Тендер шалгаруулалтын журмыг сонгохдоо тухайн бараа, ажил, үйлчилгээний нийт төсөвт өртгийг үндэслэл болгоно", Засгийн газрын 2013 оны 68 дугаар тогтоолоор баталсан "Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах ажиллагаанд мөрдөх журмыг сонгоход баримтлах босго үнэ"-ийг тус тус мөрдөөгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-т "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол албаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох" журмын 4.2.1-т заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Худалдан авах ажиллагаанд гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах тендер зохион байгуулаагүй зөрчлийг арилган, биелэлтийг 2021 оны 9 дүгээр сарын 15-ны өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх;
2. Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Жижиг, дунд үйлдвэрийг хөгжүүлэх газрын дарга Я.Эрдэнэсайхан, ерөнхий нягтлан бодогч Б.Сэргэлэн нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:
АУДИТЫН ДӨРӨВДҮГЭЭР ГАЗРЫН ЗАХИРАЛ,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

АХЛАХ АУДИТОР

Я.САМБУУНЯМ

Б.ЭРДЭНЭЗУЛ

Монгол Улс, Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, 1-р хороо, Бага тойруу-3, Засгийн газрын 4 дүгээр байр,
Утас 51-264230

\\10.10.10.20\Bichig_Khereg\Alban_Shaardlaga\2021\0325auditin 2-R_Gazar60.Docx

001080866



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

᠒᠐᠒1 оны ᠒᠘ дугаар сарын ᠒᠘

№ 460/АД/16᠐᠐᠐᠖᠘

Улаанбаатар хот

САГ - ᠒᠐᠒1 / 14 / САА - ᠑᠓᠑᠒
Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд хийсэн Жижиг, дунд үйлдвэрийг хөгжүүлэх сангийн 2020 оны санхүүгийн тайлангийн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

- Жилийн эцсийн санхүүгийн тайлан гаргахын өмнө авлагын тооцоо үүссэн нийт харилцагчдын 57.1 хувь буюу 156,314.6 сая төгрөгийн, нийт өглөгийн 4.6 хувь буюу 2,097.0 сая төгрөгийн үлдэгдлийг баталгаажуулаагүй;
- Тооцоо нийлсэн зарим аж ахуйн нэгжийн авлага, өглөгийн үлдэгдэл дэлгэрэнгүй журналын үлдэгдлээс нийт 195.4 сая төгрөгөөр зөрүүтэй байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.6-д "дотоод аудитын үйл ажиллагааг хэрэгжүүлэх", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.2-т "Хөрөнгө, төлбөр тооцооны тооллогыг дараах тохиолдолд заавал хийнэ", 12.2.1-д "жилийн санхүүгийн тайлан гаргахын өмнө", 13 дугаар зүйлийн 13.7-д "Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно", 20 дугаар зүйлийн 20.2.6-д "эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах" гэж заасантай тус тус нийцэхгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-т "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох" журмын 4.2.1-т заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Жилийн эцсийн санхүүгийн тайлан гаргахын өмнө харилцагчидтай тооцоо нийлж баталгаажуулах арга хэмжээг авч, албан шаардлагын биелэлтийг 2021 оны 11 дүгээр сарын 15-ны өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх;
2. Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Жижиг, дунд үйлдвэрийн газрын дарга Я.Эрдэнэсайхан, ерөнхий нягтлан бодогч Б.Сэргэлэн нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

АУДИТЫН ДӨРӨВДҮГЭЭР ГАЗРЫН ЗАХИРАЛ,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

Я.САМБУУНЯМ

АХЛАХ АУДИТОР

Б.ЭРДЭНЭЗУЛ

Монгол Улс, Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, 1-р хороо, Бага тойруу-3, Засгийн газрын 4 дүгээр байр,
Утас 51-264230

10.10.20\Bichig_Khereg\Alban Shaardlaga\2021\0325auditin 2-R Газар59.Docx

0᠑1᠐8᠒863

